



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/157

Булган сум

Нийлүүлэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан аймгийн Нэгдсэн эмнэлэгт бөөр орлуулах гемодиализын аппарат худалдан авах (2ш) нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу нийлүүлэгчээр шалгарсан “Ихшүүдэргэнэ импорт” ХХК-тай 120,000,000 (нэг зуун хорин сая) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Нэгдсэн эмнэлэг (Б.Шижирбаатар)-т олгосугай.

2.Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн аван данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Нэгдсэн эмнэлгийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Шижирбаатар)-д үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан барааг холбогдох хууль, журам, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Ихшүүдэргэнэ импорт” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Н.Мөнгөнзагас)-д даалгасугай.

4.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5.Тус барааны санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010237

Аймгийн Засаг даргын 2025 оны
03 дугаар сарын 14-ны өдрийн А/157 дүгээр
захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Бараа нийүүлэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 20-25 хоногийн дотор	Б.Шижирбаатар
2	Баталгаат хугацаа	24 сар	Б.Шижирбаатар
3	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Батцогт
4	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Д.Батцогт
5	Алданги	Хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт